

“ХАМБА НОМУН ХАНЫ БУМАН ЗАРЛИГААС ӨВЧНИЙ ЯЛГАЛЫГ САЙТАР НОМЛОСОН ТОДОРХОЙЛОЛ ХЭМЭЭХ ОРШИВОЙ” ЗОХИОЛД ГАРЧ БУЙ ӨВЧНИЙ АНГИЛЛЫГ ICD-10-Р ӨВЧНИЙ АНГИЛЛЫН НЭРШИЛТЭЙ ХАРЬЦУУЛАХ НЬ

Гангаа Болорцэцэг¹, Базаррагчаа Мягмардаш¹, Лхагва-очир Анхцацрал², Эрдэнэцогт Мөнхтэмүүлэн¹, Түмэнбат Цэцэгдарь¹, Шарав Болд^{1*}

Уламжлалт Анагаах Ухааны тэнхим

¹Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль

²“Ач” Анагаах Ухааны Их Сургууль

*Цахим хаяг: shrvbold@gmail.com

COMPARISON OF DISEASE CLASSIFICATIONS IN “A COMPREHENSIVE EXPLANATION OF DISEASE DIFFERENTIATION FROM THE DECREES OF KHAMBA NOMUN KHAN” WITH ICD-10 CLASSIFICATION

Bolortsetseg Gangaa¹, Myagmardash Bazarragchaa¹, Ankhtsatsral Lkhagva-Ochir², Munkhtemuulen Erdenetsogt¹, Tsetsegdari Tumenbat¹, Bold Sharavyn^{1*}

Department of Traditional Medicine

¹Mongolian University of Pharmaceutical Sciences

²“Ach” Medical University

*Email: shrvbold@gmail.com

Abstract

Introduction

The development of Mongolian traditional medicine (MTM) has historical roots in Indian Ayurvedic and Tibetan medical systems. The Four Medical Tantras significantly influenced MTM's education, theory, and practice. Disease classifications within the Four Medical Tantras have long been foundational for diagnosis, treatment, and teaching.

Mongolian scholar Lama Gegeen Luvsandanzanjantsan expanded the Four Medical Tantras' classification system in his seminal work, A Comprehensive Explanation of Disease Differentiation from the Decrees of Khamba Nomun Khan. This study compares disease classifications from this work with the International Classification of Diseases (ICD-10) specific to Traditional Medicine (TM).

Goal

To analyze and compare the disease classifications in A Comprehensive Explanation of Disease Differentiation from the Decrees of Khamba Nomun Khan with ICD-10 TM classifications, providing detailed insights.

Methods

The study utilized the following materials:

- Lama Gegeen Luvsandanzanjantsan's A Comprehensive Explanation of Disease Differentiation from the Decrees of Khamba Nomun Khan.
- ICD-10 classifications of diseases. Research methods included source study, comparative analysis, and systematic categorization.

Results

Lama Gegeen Luvsandanzanjantsan authored four volumes comprising 79 sections and 220 chapters, detailing 404 diseases classified by “place,” “cause,” “nature,” and “root.” While aligned with the Four Medical Tantras, his classifications offer deeper specificity, such as diseases caused by combinations of the five vital energies (wind, bile, phlegm, etc.).

This study focused on 101 diseases classified by “place” and 101 by “cause” for comparison.

The ICD-10 TM classification system organizes diseases into 15 segments based on diagnostic criteria and etiology. A comparative analysis of the 202 diseases from Lama Gegeen's text revealed alignment and divergence in categorization principles.

Conclusion

Lama Gegeen Luvsandanzanjantsan's “A Comprehensive Explanation of Disease Differentiation” (1639–1704), written in

Tibetan, provides an extensive classification of 404 diseases. While the ICD-10 TM system organizes diseases into 15 categories with etiology-based diagnostics, it lacks the detailed elaboration found in Lama Gegeen's work. Integrating these classification systems could enhance diagnostics, treatment strategies, and research in traditional medicine.

Keywords: ICD-10, Lama Gegeen Luvsandananzanjan, disease classification, Traditional Medicine.

ҮНДЭСЛЭЛ

Аливаа анагаах ухаанд өвчин нэгийг бусдаас нь ялган танихын тулд өвчний ангилалзүй гэж байдаг буюу өөрөөр хэлбэл ижил шинжийг үзүүлсэн ч эмгэг жамын хувьд ялгаатай тоолшгүй олон өвчнүүд байдаг бол тэднийг хооронд нь ялган салгаж оношлох, тохирсон эмчилгээг хийхэд бидэнд өвчний ангилал машид чухалтай билээ.

МУАУ-ы хөгжил нь эхэн үедээ Энэтхэгийн “Аюурвед”-ийн анагаах ухаантай, дунд үеийн сүүл хэсгээсээ хойш Төвөдийн анагаах ухааны түүхтэй нарийн шижмээр холбоотой хөгжихдөө “Анагаах Ухааны Дөрвөн үндэс” зохиолыг Монголын анагаах ухааны сургалт, онол, практикийн үндэс болгосоор ирсэн¹. Чухам энэ үеэс эхлэн “Анагаах ухааны 4 үндэс” зохиолын өвчний ангиллыг барьж сургалт болон оношилгоо, эмчилгээнд хэрэглэж эхэлжээ.

Бид Уламжлалт анагаах ухааны олон эрдэмтдийн бүтээлийг уншиж судлах явцдаа Анагаах ухааны дөрвөн үндэс зохиолоос гадна өвчний ангилалын чиглэлээр бичигдсэн бүтээл нь Монгол эрдэмтэн Ламын Гэгээн Лувсанданзанжанцаны “Хамба номун ханы буман зарлигаас өвчний ялгалыг сайтар үзүүлсэн тодорхойлол хэмээх оршивой” бүтээл байгааг олж мэдсэн бөгөөд тус зохиол нь Анагаах ухааны дөрвөн үндэс зохиолын өвчний ангиллыг тайлбарлан дэлгэрүүлсэн зохиол юм. Энэхүү зохиолд буй өвчний дэлгэрэнгүй ангиллыг ӨОУ-ын ICD-10 ангиллын “УАУ-ы өвчний бүлэг, оношийн ангилал, кодийн хураангуйн бүтэц өвчний ангилал”-тай дүйцүүлэн үзэж ижил төстэй болон ялгаатай талыг тодруулан гаргах нь Монголын УАУ-ы эмнэлзүйн болон өвчний оношийн бүртгэл судалгааны хөгжилд онолын гарын авалга болох, судалгааны хэрэглэгдэхүүн болох ач холбогдолтой юм хэмээн үзэж тус сэдвийг сонгон авав.

Зорилго: “Хамба номун ханы буман зарлигаас өвчний ялгалыг сайтар номлосон тодорхойлол хэмээх оршивой” судрын өвчний ангиллыг ICD-10

ангиллын “УАУ-ы өвчний бүлэг, оношийн ангилал, кодийн хураангуйн бүтэц өвчний ангилал”-харьцуулан ижил болон ялгаатай талыг тогтоон, тайлбар хийх.

Зорилт:

Ламын гэгээн Лувсанданзанжанцаны анагаах ухааны бүтээлүүдийг тодруулан, “Хамба номун ханы буман зарлигаас өвчний ялгалыг сайтар үзүүлсэн тодорхойлол хэмээх оршивой” бүтээлийн онцлогийг тодруулан гаргах

Ламын Гэгээн Лувсанданзанжанцангийн “Өвчний ялгалыг сайтар үзүүлсэн тодорхойлол хэмээх оршивой” зохиол болон ӨОУ-ын 10-р ангиллын “УАУ-ы өвчний бүлэг, оношийн ангилал, кодын хураангуйн бүтэц өвчний ангилал”-ыг харьцуулж ижил болон ялгаатай талыг тогтоон, тайлбар хийх.

Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй:

1. Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн эх сурвалж

Ламын Гэгээн Лувсанданзанжанцан “Хамба номун ханы буман зарлигаас өвчний ялгалыг сайтар номлосон тодорхойлол хэмээх оршивой”

མཁན་ཆེན་གྱི་རྒྱལ་པོའི་གསུང་འབུམ་ལས་ནད་ཀྱི་དབྱེ་བའི་རྣམ་བཤད་གསལ་བྱེད་ཅེས་བྲ་བ་བཞུགས་མོ་
модон барын судар.

ICD-10 ангиллын “УАУ-ы өвчний бүлэг, оношийн ангилал, кодын хураангуйн бүтэц өвчний ангилал”

2. Судалгааны арга:

2.1 Сурвалж бичгийн судлалын арга: Эх бичгийн судалгааг эх бичиг судлалын өнөөгийн түвшинд аль болох ойртуулж уг эх, нэр, газар орон, гол онцлог, агуулга, эх хэрэглэгдэхүүн, галиг, тайлбар, харьцуулга, хөрвүүлэг зэргийг нэг дор хамтатган судална.

2.2 Магадлан жагсаах арга: Магадлан жагсаах буюу хяналтын хуудасны аргаар “Өвчний ялгалыг сайтар үзүүлсэн тодорхойлол хэмээх оршивой” зохиолын өвчний ангиллыг түүвэрлэн жагсааж тайлбарлан, тодруулахад ашиглана.

2.3 Харьцуулах арга: Энэ аргыг бид “Өвчний ялгалыг сайтар үзүүлсэн тодорхойлол хэмээх

оршивой” зохиолын доторх гэмийн ангилал болон орны ангилалыг ӨОУ-ын “УАУ-ы өвчний бүлэг, оношийн ангилал, кодийн хураангуйн бүтэц өвчний ангилал”-тай харьцуулахад ашиглана.

2.4. Нэгтгэн дүгнэх арга: Харьцуулалт хийсний дараа өвчний ангилалуудын ижил болон ялгаатай талуудыг гарган, тайлбар хийхэд ашиглана.

Үр дүн:

1. Ламын Гэгээн Лувсанданзанжанцангийн Төвөд хэлээр зохиосон олон зүйлийн зохиол бүтээл нийт 4 боть, 79 иж, 220 анги буй. Эдгээр зохиолоос анагаах ухааны талаар туурвисан 5 гол ном буй². Үүнд:

1. Хамба номун ханы буман зарлигаас анагаах ухааны язгуурын үндсийн тайлбар тодруулагч зул хэмээх оршивой
2. Хамба номун ханы буман зарлигаас увдист рашааны дусал оршивой
3. “Хамба номун ханы буман зарлигаас өвчний ялгалыг сайтар номлосон тодорхойлол хэмээх оршивой”
4. Хамба номун ханы буман зарлигаас хорин тавтын аймаг оршивой
5. Хамба номун ханы буман зарлигаас туулгын бүлгийг хамтатган үйлдэх жишээ хийгээд хүйтнийг ерөнхийд нь дарах рашааны найрлага, тасарсныг залгуулж гэмийг угаас гаргагч нугууд оршивой гэсэн бүтээлүүд байна.

Монгол оточ Ламын Гэгээн Лувсанданзанжанцан нь 1639-1704 оны хооронд Төвөд хэлнээ тууривсан “Өвчний ялгалыг сайтар үзүүлсэн тодорхойлол хэмээх оршивой” бүтээлдээ орны, гэмийн, эрхмийн, язгуурын нийт 404 өвчний ангиллыг тайлбарлан бичсэн бөгөөд ийнхүү тайлбар хийхдээ машид дэлгэрэнгүй ойлгомжтой гаргаж ирсэн байв. Анагаах ухааны дөрвөн үндэс зохиолоос тооны хувьд зөрөх зүйл байхгүй ч зарим ангилалд “Амь баригч тэргүүтэн таван хий, бадган, шар лугаа нийлэлдсэнийг арав хэмээн таалму” хэмээн товч дурдсаныг тус бүрд нь хэрхэн нийлэлдсэн өвчин байхыг ялган тэмдэглэж үлдээжээ. Тиймээс энэхүү 404 өвчний ангилал дундаас Гэмийн үүднээс ялгасан 101 өвчин болон Орны үүднээс ялгасан 101 өвчнийг тусгайлан сонгож судалганад оруулав.

ӨОУ-ын 10-р ангиллын “УАУ-ы өвчний бүлэг, оношийн ангилал, кодын хураангуйн бүтэц өвчний ангилал” нь өвчнийг Увдисын үндсийн 15 үесийн ангилалаар гаргасан тул дээрх орны болон гэмийн үүднээс ялгасан 202 өвчнийг түүж аван харьцуулав.

Тус судалгааны хэрэглэгдэхүүн болгон авсан бүтээл дэх Орны үүднээс ялгасан 101 өвчний ангиллыг ӨОУ-ы ICD-10 “УАУ-ы өвчний бүлэг, оношийн ангилал, кодийн хураангуйн бүтэц өвчний ангилал”-аас түүн гаргаж харьцуулсан үр дүнг дараах зургаар үзүүлэв.




Figure 1. Comparative classification based on the dwelling location of disorders

Ламын Гэгээн Лувсанданзанжанцангийн тус бүтээл дэх орноор ангилсан өвчний ангилал нь “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн “Номлолын үндэс” дэх 12-р бүлгийн орны үүднээс ялгасан өвчний ангилалтай ижил 101 өвчин ангилагдсан бөгөөд үүнийг ӨОУ-ын 10-р ангиллаас түүхэд нийт 314 өвчний ангилал байна. Энэхүү тооны зөрүү нь ӨОУ-ын 10-р ангилалд зарим өвчнийг тухайн өвчний ялгалаар дэлгэрүүлэн гаргасанаас үүдсэн байна. Жишээ нь “Өвчний ялгалыг сайтар үзүүлсэн тодорхойлол хэмээх оршивой” зохиолд сэтгэлд орших өвчинд Солиоруулагч болон Умартуулагч гэсэн 2 өвчнөөр авч үзсэн бол ӨОУ-н 10-р ангилалд галзууруулагч адын өвчнийг хийнээс болсон галзуу TMS01.1, шараас болсон галзуу TMS01.2, бадганаас болсон галзуу TMS01.3, хурмалаас болсон галзуу TMS01.4, сэтгэл энэлэлээс болсон галзуу TMS01.5, хороос болсон галзуу TMS01.6, адаас болсон галзуу TMS01.7 гэж 7 ангилан, умартуулах өвчнийг хийнээс TMA00, шараас TMB00, бадганаас TMC00, хороос TMU00, адаас TMS00 болсон умартуулах өвчин TMS02 хэмээн 5 ангилан нийт 12 ангилсан байна. Энэ мэтээр зарим нэг

өвчнийг дотор нь ялган дэлгэрүүлснээс 213 өвчний нэршлийн ялгаа гарч байна.

Мөн цээжин биеийн өвчний ангилал доторх Чихний өвчний ангиллыг дотор нь Хийнээс болсон чихний өвчин TMJ02.1, Шараас болсон чихний өвчин TMJ02.2, Бадганаас болсон чихний өвчин TMJ02.3, Цуснаас болсон чихний өвчин TMJ02.4, Чихнээс идээ гоожих / дээрх дөрөв хурснаас болж/ TMJ02.5, Гүвдрүү гарах TMJ02.6, Дуутай дүлий TMJ02.7, Хулхи тэргүүтнээр бөглөрч дүлийрэх TMJ02.8, Хуурай дүлий TMJ02.9, Эхийн хий хүүхдэд алдсан дүлий TMJ02.10 гэж шалтгаанаар нь нарийн дэлгэрэнгүй ангилсан боловч уруулын өвчин TMJ04.1, шүдний өвчин TMJ04.3, хэлний өвчин TMJ04.4, тагнайн TMJ04.5 өвчнийг дэлгэрүүлж ангилсангүй орхисон байна.

“Өвчний ялгалыг сайтар үзүүлсэн тодорхойлол хэмээх оршивой” зохиол дох Гэмийн үүднээс ангилсан 101 өвчнийг нарийвчилсан байдлаар ӨОУ-ы ICD-10 ангиллаас түүн гаргаж гэм тус бүрээр харьцуулсан үр дүнг доорх зургаар үзүүлэв.




Figure 2. Comparative analysis of wind disorders by pathogenic cause

Гэмийн үүднээс ялгасан хийн өвчний ангилалд харьцангуй тооны ялгаа байхгүй ч орноор ялгасан хийн өвчний ангилалд тус орныг нарийн дэлгэрэнгүй гаргаж ӨОУ-ын 10-р

ангилалд оруулсан байна. Жишээ нь “Өвчний ялгалыг сайтар үзүүлсэн тодорхойлол хэмээх оршивой” зохиолд: Ясанд шунах хий өвчин гэж байгааг ӨОУ-ын 10-р ангилалд: Хий

ясанд шунах ТМА00.26.1, Хий үесэд орших ТМА00.26.2, Хий чөмгөнд орших ТМА00.26.3, Хий шимд орших ТМА00.26.4 хэмээн 4 ангилж

ингэснээс гэмээр ялгасан хийн өвчин нийт 52 өвчин болсон байна.




Figure 3. Comparative analysis of bile disorders by pathogenic cause

Гэмийн үүднээс ялгасан шарын өвчний ангилалд буй тооны ялгаа нь ерөнхийд нь ялгасан шарын өвчний ангилал болон орноор ялгасан шарын өвчний ангилалд тус тус нарийн дэлгэрэнгүй гаргаж ӨОУ-ын 10-р ангилалд оруулсан байна. Жишээ нь: “Өвчний ялгалыг сайтар үзүүлсэн тодорхойлол хэмээх оршивой” зохиолд: Галын илч буюу шингээч шарын өвчнийг ӨОУ-ын 10-р ангилалд:

Шингээгч шар хийн нөхцөлөөр гадагш сарних ТМВ00.1.1, Шингээгч шар эс шингэсний нөхцөлөөр гадагш сарних ТМВ00.1.2, Шингээгч шар бадганы нөхцөлөөр гадагш сарних ТМВ00.1.3, Шингээгч шар цусны нөхцөлөөр гадагш сарних ТМВ00.1.4 хэмээн 4 ангилж ингэснээр гэмээр ялгасан шарын өвчин нийт 50 өвчин байна.




Figure 4. Comparative analysis of phlegm disorders by pathogenic cause

Гэмийн үүднээс ялгасан бадган өвчний ангилалд харьцангуй тооны ялгаа бага байгаа ч орноор ялгасан бадган өвчний ангилалд тус орныг нарийн дэлгэрэнгүй гаргаж ӨОУ-ын 10-р ангилалд оруулсан байна. Жишээ нь “Өвчний ялгалыг сайтар үзүүлсэн тодорхойлол хэмээх оршивой” зохиолд: Савд унах бадган өвчнийг ӨОУ-ын 10-р ангилалд: Бадган ходоодонд унах ТМС00.12.1, Бадган олгойд унах ТМС00.12.2, Бадган гэдсэнд унах ТМС00.12.3, Бадган цөсөнд унах ТМС00.12.4, Бадган давсганд унах ТМС00.12.5, Бадган умайд унах ТМС00.12.6 хэмээн 6 ангилж ингэснээс гэмээр ялгасан бадганы өвчин нийт 42 өвчин байна.

Дүгнэлт:

Монгол оточ Ламын Гэгээн Лувсанданзанжанцангийн анагаах ухаантай холбогдох 5 бүтээлээс 1639-1704 оны хооронд Төвөд хэлнээ бичигдсэн “Өвчний ялгалыг сайтар үзүүлсэн тодорхойлол хэмээх оршивой” бүтээл нь орны, гэмийн, эрхмийн, язгуурын нийт 404 өвчний ангиллыг тайлбарлан бичсэн байна.

ӨОУ-ын ICD 10-р ангиллын “УАУ-ы өвчний бүлэг, оношийн ангилал, кодын хураангуйн бүтэц өвчний ангилал” нь өвчний ангиллыг 15 үесээр ангилан гаргаж ирэхийн зэрэгцээ аливаа өвчнийг үүсгэх шалтгаанаар нь дэлгэрүүлж оношилгоонд шууд ашиглагдахаар гаргасан боловч зарим өвчнийг нарийн дэлгэрүүлсэнгүй гаргажээ. Тиймээс цаашид дээрх 2 ангилалд байгаа давуу талуудыг нийлүүлэн авч УАУ-ы өвчний шинэчилсэн ангилал гаргавал өвчний оношилгоо, эмчилгээ болон бүртгэл судалгааны ажилд дэвшил авчрах сайн тайлтай гэж дүгнэлээ.

Хэлцэмж:

Анагаах ухааны практикт өвчлөлийг тодорхой шалгуурын дагуу ангилан бүлэглэсэн тогтолцоог өвчний ангилал гэх бөгөөд Австралийн статистик эмч Франк Боссир Лактрок (1706-1777) анх удаа өвчний системчлэн ангилснаас хойш боловсронгуй болсон³. Харин уламжлалт анагаах ухааны өвчнийг “Анагаах ухааны 4 үндэс” зохиолын

өвчний ангиллын дагуу дараах байдлаар ангилан авч үзэж байна. Үүнд: Өвчний шалтгааны үүднээс, шүтээний үүднээс, зүйлийн үүднээс хэмээн ангилаад түүний дотор зүйлийн үүднээс ангилах нь гэмээр, эрхэмээр, орноор, зүйлээр нийт 4044. Одоо мөрдөгдөж байгаа ӨОУ-ын 10-р ангиллын Уламжлалт анагаах ухааны өвчний ангилал ч мөн энэ ангиллын дагуу хийгдэж, 1910 оноос хойш мөрдөгдөж, сайжирч засагдсаар ирсэн. Үүнтэй холбоотой өвчний ангиллын судалгаа ч цөөнгүй хийгдсээр ирсэн байна.

Ламын Гэгээн Лувсанданзанжанцангийн анагаах ухааны таван зохиолуудаас судалгааны эргэлтэд орон судлагдсан зохиол нь дараах 2 зохиол байна. Үүнд:

Б.Сумъяацэрэн “Хамба номун хааны “Увдист рашааны дусал” сударт буй илт өгүүлэх нэр, зарим эмийн тайлбар^{4,5}”, М.Шинэгэрэл “Нэр нь л мэдэгдэх өнгөт эмийн сударт буй амьтны гаралтай зарим эмийн хэрэглээг тодруулах нь^{6,7}” магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Тус судалгаануудад дурдахдаа “Хамба Номун хан Лувсанданзанжанцан таван ухаанд нэвтэрсэн эрдэмтнээр барахгүй Монгол анагаах ухааны эрдэм судлалын ажлыг өргөжүүлэн улмаар анагаах ухааныг сурч эзэмшсэн анхны монгол эмч Энэтхэг, Төвөдийн эрдэмтдийн шилдэг бүтээлүүдэд дүгнэлт, тайлбар хийсэн хүн гэж үздэг. Тиймээс Хамба Номун хан Лувсанданзанжанцангийн анагаах ухааны бүтээлүүд өөрийн туршлагаас гадна Энэтхэг, Төвөдийн анагаах ухааны мэргэдийн олон арван ном судар, гарын авлагыг нарийвчлан судалж бичсэн хамгийн итгэмжтэй эмчилгээний аргуудыг багтаасан бүтээл болох нь тодорхой байна” хэмээн дүгнэсэн байна. Энэ нь Ламын Гэгээн Лувсанданзанжанцангийн анагаах ухаанд оруулсан хувь нэмэр үнэлшгүй бөгөөд цааш нь лавшруулан судлуштай бүтээл олон байгаа гэдгийг харуулж байгаа юм.

Харин УАУ-ы өвчний ангиллын талаар хийгдсэн өөр нэг судалгаа нь Г.Одонцэцэг “Уламжлалт анагаах ухаан дахь өвчний ангиллын судалгаа” докторын зэрэг горилсон

нэг сэдэвт бүтээл бөгөөд тус судалгаандаа “УАУ-ны өвчний ангиллын зарчмуудын уялдаа холбоог тодотгон илрүүлж, ялгавартай арван таван гэмийн хавсрах, хурах 1940 хувилбар, хорин бэлгэ чанарын арвидах, хорогдох 4680 хувилбар оршиж буйг судлан тогтоосон нь бодгаль нэг бүрд нийцсэн оношилгоо, эмчилгээг хийх зарчмын үндэслэл болсон”³ гэсэн бөгөөд түүний хийсэн судалгаа нь 404 өвчний эрхэмийн, орны, язгуурын, гэмийн ангиллаас тусдаа хэмээн дүгнэсэн байна.

Ном зүй

1. Болд Ш. Монголын Анагаах Ухааны түүх. Улаанбаатар. 2013; (4):49
2. Болд Ш. Хамба номун ханы буман зарлигаас “Өвчний ялгалыг сайтар үзүүлсэн тодорхойлол хэмээх оршивой”. УБ; 2024:6
3. Одонцэцэг Г. “Уламжлалт анагаах ухаан дахь өвчний ангиллын судалгаа” Анагаах ухааны докторын зэрэг горилсон бүтээл. Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль. 2016:9,41
4. Ютиг Ёндонгомбо. Анагаах ухааны дөрвөн үндэс. Өвөр Монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо. Хөх хот. 1959.
5. Сумьяацэрэн Б. “Хамба номун хааны Увдист рашааны дусал сударт буй илт өгүүлэх нэр, зарим эмийн тайлбар” Анагаах ухааны магистрын зэрэг горилсон бүтээл. Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль. 2022:7
6. Шинэгэрэл М. “Нэр нь л мэдэгдэх өнгөт эмийн сударт буй амьтны гаралтай зарим эмийн хэрэглээг тодруулах нь” магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Эм зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль. 2022:12